

**ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Монгол Улсын Их Хурлын 2004 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс, хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын баримт бичиг”-т хүн амын бүртгэл, мэдээлэл, шилжих хөдөлгөөний талаарх судалгааны чанарыг олон улсын түвшинд хүргэж, бүртгэлд хамрагдалтын хэмжээг байнга нэмэгдүүлэх бодлого баримтлахаар тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 45 дугаар тогтоолын Хавсралтын 5.2.7-д “Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд сурталаас ангид байх эрх зүйн орчныг бүрдүүлж, иргэдийн эрхийг батлагаажуулна”, “нэг иргэн, нэг бүртгэл” хөтөлбөр хэрэгжүүлэх замаар бүртгэлийн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлж, төрийн... үйлчилгээг жигд, тэгш авах нөхцөлийг бүрдүүлнэ” гэж тус тус заасан.

Одоо мөрдөгдөж буй Иргэний бүртгэлийн тухай хуулиар Монгол Улсын иргэний бүртгэл болон түүнийг эрхлэх байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.Иргэний бүртгэлийн тухай хууль 1999 онд батлагдсанаас хойш нийт 12 удаа, давхардсан тоогоор 100 гаруй зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт орж хуулийн анхны бичвэрээс нилээд зүйл, заалт өөрчлөгдсөн байна.

2.2009 онд батлагдсан Улсын бүртгэлийн ерөнхий хуулиар улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоо, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдэж, Иргэний бүртгэлийн тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулсан хэдий ч хуулийн нэр томьёо, бүртгэлийн үйл ажиллагааг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, нэгдсэн системд оруулах, иргэний бүртгэлтэй холбоотой хууль тогтоомжийн уялдааг хангах, давхардал, зөрчлийг арилгах зарим асуудал орхигдсон. Тухайлбал, Иргэний бүртгэлийн тухай хуулийн 5.1-д заасан бүртгэл нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 5.3-т заасан бүртгэлийн төрлөөс өөр байгаа нь хуулийн нэр, нэр томьёоны сацуу ихэнх зүйл, заалтад өөрчлөлт орохоор байна.

3.Улсын Их Хурлын 2009 оны 100 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын иргэний шинэчилсэн бүртгэлийг явуулах, үүнтэй холбогдуулан иргэний цахим үнэмлэх олгох суурь бүтэц, иргэний биеийн давхцахгүй өгөгдөлд суурилсан мэдээллийн санг бий болгох үйл ажиллагааны үр дүнд тухайн иргэний мэдээллийг агуулсан, өндөр нууцлал бүхий мэдээллийн санг бүрдүүлсэн.

Иймд Монгол Улсын иргэний шинэчилсэн бүртгэл болон практикт гарч байгаа, хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай шинэ харилцаа болох биеийн давхцахгүй өгөгдөл(гарын хурууны хээ)-ийн бүртгэл, хүйс өөрчлөгдсний бүртгэлийн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгтэй байна.

4.Хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэлтэй асуудлыг арилгах, боловсронгуй болгох зорилгоор иргэний улсын бүртгэлд бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичгийг төрөл тус бүрээр заах, бүртгэлийн аль шатны байгууллагад хандах болон бүртгэлийн байгууллагаас бүртгэх хугацааг тодорхой тусгах шаардлагатай.

5.Иргэдийн шилжилт хөдөлгөөн /түр болон байнга оршин суух газраа чөлөөтэй сонгох эрх/-ийг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан боловч уг бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт хангалттай бус, иргэнд хүндрэл, чирэгдэлтэй байгааг харгалзан энэ талаарх зохицуулалтыг хуульд нарийвчлан тусгах, бүртгэлийг боловсронгуй болгох асуудал зүй ёсоор тавигдаж байна.

6.Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 20 дугаар тогтоолоор сум, дүүрэг, хорооны бүртгэлийн ажилтныг улсын бүртгэлийн байгууллагын бүтцэд шилжүүлэн ажиллуулахаар шийдвэрлэсний дагуу Монгол Улсын хэмжээнд бүртгэлийн үйл ажиллагааг мэргэжлийн нэгдсэн арга зүй, бодлого, чиглэлээр хангах, үйл ажиллагааны стандарт, хяналт шалгалтыг бүх шатанд нэвтрүүлэх замаар бүртгэлийн чанар хүртээмжийг сайжруулж, иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах боломжтой болсон.

Иймд сум, дүүргийн улсын бүртгэгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, зарим бүртгэлийг бүртгэх боломжтой байдлыг харгалзан бүртгэлийг иргэдэд ойртуулах үүднээс иргэний улсын зарим бүртгэлийг хөтлөх зохицуулалтыг бий болгох нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэлийг хөтлөхөд Засаг даргын шийдвэрийг үндэслэж байгаа зохицуулалтыг өөрчлөх шаардлагаар хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулсан.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг нийт 6 бүлэг, 30 зүйлтэй байхаар боловсруулж, дараахь зохицуулалтыг тусгана:

1/хуулийн төслийн нэрийг Улсын бүртгэлийн ерөнхий хуультай нийцүүлэн Иргэний улсын бүртгэлийн тухай хууль гэж өөрчилж, иргэний улсын бүртгэл хөтлөх болон түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулахаар тодорхойлно.

2/хуульд оновчгүй хэрэглэсэн болон тодорхойлох шаардлагатай нэр томъёо Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон бусад хуультай нийцүүлэн тодорхойлж, тусгана.

3/Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 5.3-т заасан бүртгэл болон хуульд шинээр нэмэгдэж байгаа бүртгэл тус бүрээр иргэдээс бүрдүүлэх баримт бичиг, бүртгэх байгууллага, бүртгэл хийх журмыг нарийвчилж, тохиолдол бүрээр тогтооно.

4/Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний иргэний улсын бүртгэлийн асуудлыг холбогдох бусад хуультай нийцүүлэх чиглэлээр бүртгэл тус бүрт өөрчлөлт оруулна.

5/сум, дүүрэг, хорооны улсын бүртгэгч, хилийн чанадад ажиллаж байгаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн болон Консулын газрын иргэний бүртгэл хариуцсан ажилтны иргэний улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааг өргөжүүлж, зарим төрлийн иргэний улсын бүртгэл хийх боломжийг бүрдүүлнэ.

6/иргэн улсын бүртгэлд бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтаас бүртгэлийн байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээлэл бүхий баримт бичгийн хуулбар, лавлагаа зэргийг хасах, улсын бүртгэгч мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээлэл, нотлох баримт бичигт үндэслэн бүртгэлийг хөтлөх, түүнтэй холбоотой зохицуулалтыг нэмж тусгана.

7/иргэний улсын бүртгэлд бүртгүүлэх одоо мөрдөгдөж байгаа хугацааг хэвээр хадгална. Харин иргэний бүртгэлийн байгууллагаас баримт бичгийг хүлээн авч, бүртгэл хөтлөх хугацааг судалгааны үндсэн дээр, боломжит байдлаар тогтоож, бүртгэл тус бүр дээр хугацаа зааж, тодорхой болгоно.

8/шилжилт хөдөлгөөн, Монгол Улсын харьяат болсон, иргэний харьяаллаа сэргээн тогтоосон, харьяатаас гарсан, үрчлэлт, хүйс өөрчлөгдсөн, овог, нэр өөрчлөх, гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй холбоотой бүртгэлээс бусад бүртгэлийг засаг захиргааны нэгж харгалзахгүй бүртгэдэг байхаар зохицуулна.

9/зарим төрөл(овог, эцэг/эх/-ийн нэр, нэр өөрчилсөний, гэрлэлт цуцалсаны, үрчилсний)-ийн бүртгэлд бүртгэлийн гэрчилгээг олгодог зохицуулалтыг хасаж, зөвхөн төрсний, гэрлэсний, нас барсны бүртгэлд гэрчилгээ олгож байхаар шийдвэрлэнэ.

10/овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсөний бүртгэлийг хөтлөхөд Засаг даргын шийдвэрийг үндэслэх асуудлыг өөрчилнө.

11/иргэдийн шилжилт хөдөлгөөн/байнга болон түр/-ий бүртгэлийн зохицуулалтыг нарийвчлан тусгана.

12/иргэний улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, иргэний баримт бичгийг дахин олгох, иргэний бүртгэлийг сэргээн тогтоох, хүчингүй болгохтой холбоотой харилцааг тусгана.

13/иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан, иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн хадгалалт, хамгаалалтай холбоотой харилцааг тодорхойлж, тусгана.

14/иргэний улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжийн биелэлт болон үйл ажиллагаанд тавих хяналт, иргэний улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн иргэнд хүлээлгэх хариуцлагын асуудлыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч, дараахь эерэг үр дүн гарна гэж тооцоолж байна:

1/Иргэний улсын бүртгэлийн хуулийг Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон бусад хуультай нийцүүлснээр хуулийн давхардал, зөрчлийг арилгах, зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал шийдэгдэнэ;

2/иргэний бүртгэлд бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичгийг төрөл тус бүрээр тодорхой заах, бүртгэлийн аль шатны байгууллагад хандахыг тодорхой тусгаснаар бүртгэлийн шат дамжлага, бүрдүүлэх баримт бичгийн тоо багасах, зарим төрлийн

бүртгэлийн зохицуулалтыг нарийвчлан тусгаснаар иргэний эрхийг хангах боломж бүрдэнэ;

3/иргэний улсын зарим бүртгэлийг засаг захиргааны нэгж харгалзахгүй бүртгэх зохицуулалтыг тусгаснаар иргэнд үүсэх захиргааны болон зардлын ачааллыг багасгах боломжтой болно.

4/хуулийн төсөлд иргэний улсын бүртгэлийн лавлагааг цахимаар олгох, иргэний улсын бүртгэлийг цахимаар хийх боломжийг тусгаснаар бүртгэлийг хөнгөвчлөх, тэдгээрийг шийдвэрлэх боломжтой болно.

5/гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа иргэн хилийн чанадад ажиллаж байгаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газарт хандан иргэний үнэмлэх авах боломжтой болно.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт ачаалал нэмэгдэхгүй.

Дөрөв.Хуулийн төсөл нь бусад холбогдох хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Хууль хүчингүй болсонд тооцох тухай/Иргэний бүртгэлийн тухай хууль/ хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг тус тус боловсруулна.

-----oO-----